



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
НЯМ-ОСОРЫН УЧРАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2026.04.23 № 21

Боловсролын зээлийн сангийн
эргэн төлөлт, хариуцлагын талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна.

Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүйн дэд хорооны дарга Б.Хэрлэн Боловсролын зээлийн сангийн зээлийн хөрөнгөөр 2008-2013 онд ХБНГУ-ын Подсдамын их сургуульд суралцсан, зээлээ төлсөн эсэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах асуудал бүрээр:

1. Удирдлагын академийн Зөвлөгөө өгөх төвийн эрхлэгч асан (суралцах үеийн албан тушаал) Бадарчийн Хэрлэн нь БСШУ-ын сайдын 2008 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн А/476 дугаар тушаалаар Боловсролын зээлийн сангийн зээлийн бүрэн санхүүжилтээр ХБНГУ-ын Подсдамын их сургуульд суралцсан тухай:

-БСШУ-ын сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар батлагдсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистр, докторт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам" /цаашид "журам" гэх/-ын 4 дэх хэсэгт заасан "Зарлагдсан мэргэжлийн чиглэлийн дагуу бакалавр, магистр /докторантурт суралцагчдад хамаарна/-аас доошгүй боловсролтой/ сургалтын голч дүн 3.25 ба түүнээс дээш/, мэргэжлээрээ 2 ба түүнээс дээш ажилласан, эрдэм шинжилгээний ажлын туршлагатай, гадаад хэлний бэлтгэлтэй, олон улсын нэр хүндтэй их сургуулийн үндсэн сургалтад зарлагдсан мэргэжлийн дагуу шууд суралцахаар элссэн" гэж заасан шаардлагыг хангасан эсэх талаар мэдээлэл;

-Мөн журмын 3 болон 6 дахь хэсэгт заасан жагсаалтад Б.Хэрлэн гишүүний суралцсан ХБНГУ-ын Подсдамын их сургууль болон улс төрийн шинжлэх ухаан гэсэн мэргэжил багтаж байсан эсэх;

-Журмын 7 дахь хэсэгт заасан материалыг бүрэн бүрдүүлж оролцсон эсэх болон тус журмын 10 дахь хэсэгт заасан сонгон шалгаруулалтын комиссын дүгнэлт холбогдох хууль журмын дагуу гарсан эсэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл;

-Засгийн газрын 2008 оны 177 дугаар тогтоолын хавсралт "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын 3.1-д "Гэрээ байгуулсан суралцагчийн санхүүжилтийг суралцах сургуулийн дансанд Сургалтын төрийн сангаас шилжүүлнэ" гэж заасны дагуу Подсдамын их сургуулийн дансанд шилжсэн байх ёстой. Гэтэл ХБНГУ-ын их

2026000061

сургууль сургалтын төлбөргүй байхад зээлдэгч Б.Хэрлэн ХБНГУ-д 2008-2013 онд суралцахдаа нийт 45.308.23 ам доллар зээлийн санхүүжилтийг Боловсролын зээлийн сангаас хувийн дансандаа авсан эсэх талаар мэдээлэл;

-Боловсролын зээлийн сантай зээлдэгч Б.Хэрлэн зээлийн гэрээ байгуулсан эсэх, гэрээний сунгалт хийгдэж байсан эсэх, сургалтын төлбөрийн зээлийн барьцаанд байршуулсан барьцаа хөрөнгө байгаа эсэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл;

-Тус сургуулиас олгосон диплом нь тухайн улсын хууль тогтоомж болон Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдөх шаардлагыг хангаж байгаа эсэхийг холбогдох байгууллагаар шалгуулсан эсэх, хэрэв шалгуулсан бол тухайн дүгнэлт, баталгаажуулалтын баримтыг танилцуулах боломжтой эсэх;

-Зээлдэгч Б.Хэрлэнгийн авсан зээл 48.308,23 ам доллар, зээлийн хүү өнөөдрийг хүртэл төлөгдсөн эсэх талаар тайлбар, мэдээлэл.

2.Хариуцлага, ёс зүйн асуудлаар:

Засгийн газрын 2008 оны 177 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын 4.4-д "Суралцагч гэрээгээ зөрчсөн тохиолдолд зээлийг хүүгийн хамт Сургалтын төрийн санд буцаан төлнө" гэж заасны дагуу зээлдэгч Б.Хэрлэн 48.308,23 ам долларын зээл болон 2008 оноос хойш 18 жил ашигласан зээлийн хүүг сантай байгуулсан зээлийн гэрээний дагуу хэзээ төлж барагдуулах талаар;

-Татвар төлөгчийн хөрөнгөөр суралцсан, гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх улс төрийн болон ёс зүйн хариуцлагын талаар.

3.Боловсролын зээлийн сантай зээлийн гэрээ байгуулсан Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүйн дэд хорооны дарга Б.Хэрлэн нь хууль журам, гэрээ зөрчсөн асуудлаа нууцалсан, зээл зээлийн хүүгээ төлөхөөс зайлсхийж буй шинжтэй "би тэтгэлгээр суралцсан, Боловсролын зээлийн сангаас зээл чөлөөлөхийг хүлээж буй" гэх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгсөн. Иймд олгосон зээл, зээлийн хуримтлагдсан хүүг хэрхэн төлүүлэх талаар дэлгэрэнгүй тайлбар.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



М.НАРАНТУЯА-НАРА

2026000061